



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/НЧБ

Булган сум

**Үерийн хариу арга хэмжээний
төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн нутаг дэвсгэрт үер усны аюулын үед ажиллах хариу арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр, нөхцөл байдлын мэдээний хүснэгтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Үерийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу шуурхай, үр дүнтэй зохион байгуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн (Д.Жаргалсайхан), Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга, Онцгой комиссын гишүүн (С.Жаргалсайхан)-д, үерийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлэж, Гамшгаас хамгаалах сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн (Д.Алтаншагай), Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ш.Баасандорж) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010581



Булган аймгийн Засаг даргын 2021.01.01-ны
06 дугаар сарын 18-ны өдрийн А/Н/Дугаар
захирамжийн...-р хавсралт

БУЛГАН АЙМГИЙН ҮЕР, УСНЫ АЮУЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Төлөвлөгөөний зорилго:

Болзошгүй үер, усны аюулын үед хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг үерийн аюулаас хамгаалах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүн, сайн дурын хэсэг, иргэн, хуулийн этгээдийн бэлэн байдлыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг сайжруулахад оршино.

1.2 Зорилт:

- Болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах.
- Үерийн аюулын үед гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлж хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах.
- Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын харилцан ажиллагааг нэгтгэн удирдан зохион байгуулах.
- Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг зохион байгуулах.

1.3 Хамрах хүрээ:

Нутаг дэвсгэр нь Сэлэнгэ, Хануй, Туул, Орхон, Эг голын сав газарт бүхлээрээ хамрагдана. Намнан, Булган хаан, Ханжаргалант, Бүрэн хийгээд Эг, Сэлэнгээс хойгуур Хантай, Бүтээлийн нуруу хилийн дагуу Зэдийн нуруу нь өргөрөг дагуу баруунаас зүүн тийш сунаж байрлах бөгөөд үнэмлэхүй өндөр нь уулархаг хэсэгтээ 1600-2171 м, уулс хоорондын хөндийд 600-1000 м өндөр юм. Шарга, Цэгээн, Харгал, Айрхан зэрэг давстай нуур цөөнгүй бий.

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж агаарын температур 0,4 градус, Орон зайн тархалтаар авч үзвэл нутгийн хойд хэсгээр -0,5°C-аас -4°C хүйтэн, өмнөд хэсгээр 0°C-аас 2°C дулаан байдаг. (. 05-р сарын 11-нээс 09-р сарын 20 хүртэл дунджаар 133 хоног үргэлжилнэ. Үнэмлэхүй халуун 07-р сард 40,5 хэм, хөрсний гадаргуу дээр 66,4 градус хүрнэ. Харьцангуй чийгшил 08-р сард 67-71 хувь болно.

Булган аймаг нь Засаг захиргааны 16 сум, 1 тосгон, 75 багтай. 62026 мянган хүн ам, 17160 өрхтэй. Аймгийн төв Булган сум 12.5 мянган хүн амтай, Улаанбаатар хотоос 318 км зайд оршдог

ХОЁР. ҮЕР, УСНЫ АЮУЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Удирдан зохицуулах байгууллага	Дэмжлэг үзүүлэх байгууллага	Тайлбар
1. Удирдлага, зохион байгуулалт					
1.1	Үер болсон дуудлагыг хүлээн авч, дээд шатны байгууллагад мэдээллийг шуурхай хүргэх	Мэдээлэл хүлээн авсан даруйд	ОБГ	-	
1.2	Онцгой комиссын гишүүдийг зарлан мэдээллийн дохиогоор аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд цуглуулах	1 цагийн дотор	ОБГ	Гамшгаас хамгаалах 14 алба, 20 мэргэжлийн анги	АОК-ын 28 гишүүн
1.3	Үүссэн нөхцөл байдлыг тодотгон аймгийн Онцгой комиссын даргад танилцуулах	2 цагийн дотор	ОБГ	Онцгой комисс	-
1.4	Үерийн нөхцөл байдлын талаар Улсын Онцгой комисст мэдээлэл хүргэх	3 цагийн дотор	ОБГ	Онцгой комисс	-
1.5	Үерийн голомтын бүсийн гудамж, зам, уулзвар, гарцын зорчих хөдөлгөөнийг цагдаагийн байгууллагын хүч хэрэгслээр хязгаарлах арга хэмжээг шуурхай зохион байгуулах	2 цагийн дотор	ЦГ	Автотээврийн төв	Цагдаагийн газраас 20 албан хаагч, 4 тээврийн хэрэгсэл, Автотээврийн төвөөс 3 хүн, 1 тээврийн хэрэгсэл
1.6	Үерийн хариу арга хэмжээг авах шуурхай штабыг АЗДТГ-ын 107 тоотод байгуулах	2 цагийн дотор	ОБГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Онцгой байдлын газраас 4 албан хаагч, 1 тээврийн хэрэгсэл АЗДТГ-аас компьютер-1, принтер-1, бусад шаардлагатай тоног

		Шаардлагатай үед			АЗДТГ	ҮАБХТЧҮББ	төнхөөрөмж (бичиг хэрэг гэх мэт)
1.7	Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр нөхцөл байдлын бодит мэдээ, мэдээллийг тандах ажлыг зохион байгуулах	Шаардлагатай үед	АЗДТГ	ҮАБХТЧҮББ	АЗДТГ	АЗДТГ-1, “Сайхан-Монгол” телевиз	
1.8	Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх аймгийн Засаг даргын захирамжийг боловсруулан батлуулах	3 цагийн дотор	ОБГ	АЗДТГ		-	
1.9	Голомтын бүс, хамарсан хүрээ, учирсан хохирол, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үүрэг гүйцэтгэж буй хүн хүч, техник хэрэгслийн судалгааг гаргаж дээд шатны байгууллагад танилцуулж хариу арга хэмжээг төлөвлөх	2 цагийн дотор	АОК	Гамшгаас хамгаалах албад		14 алба, 20 мэргэжлийн анги, төрийн болон хууль сахиуулах байгууллагууд	
1.10	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулах, шаардлагатай хүн хүч техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах	3 цагийн дотор	АОК	ОБГ		-	
1.11	Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөс цаг агаарын мэдээг тогтмол авч аймгийн Онцгой комисс, шуурхай штабыг мэдээ, мэдээллээр хангах	3 цагийн дотор	УЦУОШТөв	АОК		-	
1.12	Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх	4 цагийн дотор	Шуурхай штаб	АОК		-	
1.13	Шаардлагатай үед гамшгийн голомтод ажиллах хөдөлгөөнт удирдлагын байрыг бэлтгэх, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах	Шаардлагатай үед	ОБГ	АЗДТГ		ОБГ-2 АТТөв-1 ЭМГ-1	
1.14	Үерийн голомтод шаардлагатай хүч хэрэгслийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг дайчлан хуваарилах арга хэмжээг зохион байгуулах	4 цагийн дотор	АЗДТГ	Шуурхай штаб			

1.15	Аймгийн нутаг дэвсгэрийн ажлын зургийг бэлтгэж, үерийн эрсдэлтэй болон өртсөн бүсийн байршил, хамарсан талбайн хэмжээг тодорхойлох	4 цагийн дотор	ОБГ	АЗДТГ	
1.16	Үерт өртсөн сум, багийн хүн ам, аж ахуй нэгж, байгууллагын мэдээллийг нарийвчлан гаргах	5 цагийн дотор	Шуурхай штаб	ОБГ	
1.17	Нийгмийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн судалгааг гаргаж, шаардлагатай тусламж, дэмжлэгийг үзүүлэх	6 цагийн дотор	ХХҮГ	Шуурхай штаб, СОК	
1.18	Дотоодын тусламжийг хүлээн авах, хуваарлах ажлыг зохион байгуулах	6 цагийн дотор	МУЗХ	Шуурхай штаб	
1.19	Орон гэргүй болсон иргэдийн бүртгэл, мэдээллийг гаргах	7 цагийн дотор	Шуурхай штаб	АЗДТГ, ОК	
1.20	Хохирлын урьдчилсан үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах	2 хоногийн дотор	Онцгой комисс	ЗДТГ	
2.Холбоо, зарлан мэдээллийн зохион байгуулалт					
2.1	Шуурхай мэдээ мэдээлэл солилцох зорилгоор дотоод сүлжээ үүсгэн холбоо зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх	2 цагийн дотор	ОБГ	"МХС"ТӨК	-
2.2	Радио холбоо зохион байгуулж, үерийн голомтын бүс шуурхай штаб хооронд холбоо зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх	2 цагийн дотор	ОБГ	"МХС" ТӨХК, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага	Богино долгионы суурин станц 18, хэт богино долгионы гар станц 82
2.3	Радио станц үүрэн холбоо сүлжээ ашиглан гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийг шуурхай штабтай мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх	2 цагийн дотор	ОБГ	АОК, ГХА, МА,	АОКШШ 70580119,
2.4	Үерийн нөхцөл байдал авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж, мэдээ мэдээллийг олон нийтийн сүлжээ, хэвлэл	Тухай бүр	АОК	ОБГ, орон нутгийн олон нийтийн радио телевиз	-

	мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд хүргэж телевиз, радио нэвтрүүлгийн дараалал харгалзахгүйгээр газар дээрээс нь яриа, зураг, дүрс бүхий байдлаар шууд дамжуулах ажлыг зохион байгуулах						
2.5	Цаг агаарын урьдчилсан сэрэмжлүүлэг мэдээллийг иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх	3 цагийн дотор	АЗДТГ-ын олон нийттэй харилцах алба	ОБГ	“Сайхан-Монгол” телевиз		
2.6	Үер усны аюулын нөхцөл байдал болон урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэд, олон нийтэд чанга яригчаар хүргэх	4 цагийн дотор	Сүм	ЦГ	Булган сумын дээвэр дээр байрласан чанга яригч, чанга яригчтай 2 автомашин		
3.Нөөц хангалт							
3.1	Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүнийг ажиллах нөхцөлөөр хангах	Тогтмол	Шуурхай штаб, ЗДТГ	Гамшгаас хамгаалах бүх албад			
3.2	Үерийн хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог нэгтгэн боловсруулж аймгийн Засаг даргын захирамжийг батлан шийдвэрлүүлэх	Тухай бүр	АЗДТГ	ОК			
3.3	Аймгийн Онцгой комисст иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн хандив, тусламжийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, хуваарилах, тайлагнах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	ОБГ	АЗДТГ			
3.4	Аймгийн Онцгой комисст хандив тусламжаар ирүүлсэн үлдэгдэл бараа, материаллыг үерийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад хуваарилах ажлыг зохион байгуулах	3 цагийн дотор	ОК	ЗДТГ			
3.5	Иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн хандив, тусламжийн мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, тайлагнах,	Тухай бүр	ОБГ	ЗДТГ			

	зарцуулалтыг талархал илэрхийлэх, таниулах арга хэмжээ зохион байгуулах					
3.6	Гэрээ байгуулсан аж ахуйн, нэгж байгууллагаас шатахуун, хий, шатах тослох материалыг үерийн голомтод ажиллаж байгаа шуурхай албаны автомашин, механизмыг шатах тосох материалаар хангах ажлыг зохион байгуулж, санхүүжилтыг олгох	Тухай бүр	ОК	Түлш шатахуунаар хангах алба		
3.7	Үерийн хариу арга хэмжээнд ажиллаж байгаа машин механизмд түлш, шатахууныг зөөвөрлөх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	ОБГ	ЗДТГ	Хамтран ажиллах гэрээ байгуулсан "НИК Петровис" ШТС-ын 10 тонны 3 автоцистерн	
3.8	Үерийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай штабын бие бүрэлдэхүүнийг хоол хүнсээр хангах ажлыг зохион байгуулах	6 цаг тутамд	АЗДТГ	ХХААГ	Хамтран ажиллах гэрээ байгуулсан хүнс, худалдаа үйлчилгээ явуулдаг 5 байгууллагаас татан авч, 5000 мянган хүнийг хоол, хүнсээр хангана	
3.9	Үерийн голомтод ажиллаж байгаа шуурхай бүлэг, аврагчид, нэрвэгдэгсдийг хоол хүнсээр хангах байр бэлтгэх		ОК	ЗДТГ		
3.10	Үерийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний тоог 2 цаг тутамд тодотгож, халуун хоол хүнсээр тасалдалгүй хангах	4 цагийн дотор	ОК	Сумын ЗДТГ		
3.11	Үерийн голомтод үүрэг гүйцэтгэх ажилтан, албан хаагчдыг шаардлагатай хамгаалах хувцас хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах	4 цагийн дотор	АЗДТГ	ОБГ		
4.Эрэн хайх, аврах ажиллагаа						
4.1	Онцгой байдлын газарт ирсэн дуудлага, мэдээллийн дагуу иргэдийг аврах ажиллагаа зохион байгуулах	Тухай бүр	ОБГ	АОК, ГХА, МА,		-

4.2	Гол, нууранд суусан тээврийн хэрэгсэл болон голын салаанд боогдсон иргэдийг аюулгүй байрлалд гаргах	1 цагийн дотор	ОБГ	АОК, ГХА, МА,	-	
4.3	Үерийн усанд боогдсон иргэдийг аюулгүй талбайд шилжүүлэх		АОК	ОБГ, ГХА, МА	Тогтоосон нүүлгэн шилжүүлэх 1 байршил, түр хорогдох байраар хангах ажиллагааг зохион байгуулна	
4.4	Үер болон голын усанд осолдсон буцалтгүй нэрвэгдэгчийг гаргаж холбогдох байгууллагад хүлээлгэн өгөх	Олноос хойш 30 минутын дотор	ОБГ	ШШГ, ЦГ, ЭМГ	-	
5.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ						
5.1	Нэрвэгдэгдэд эмнэлгийн анхны болон нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх, зөвөрлөх	Тухай бүр	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, сум, ерхийн эрүүл мэндийн төвүүд	Улаан загалмайн хороо		
5.2	Нэрвэгдэгдэд газар дээрх болон эмнэлэг хүртэлх эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэх	Тухай бүр	ЭМГ	Нэгдсэн эмнэлэг, сум, ерхийн эрүүл мэндийн төвүүд		
5.3	Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг дайчлан ажиллуулах	Тухай бүр нь	ЭМГ	аймгийн Нэгдсэн эмнэлэг		
5.4	Үерийн голомтод ажиллаж байгаа болон нэрвэгдсэн иргэдэд хяналт тавьж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эм хуваарилах ажлыг зохион байгуулах	Тухай бүр нь	ЭМГ	Эм ханган нийлүүлэх байгууллагууд		
5.5	Үерийн голомтод үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа ажилтан албан хаагчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүр нь	Эрүүл мэндийн алба	ЭМГ		

5.6	Үерийн аюулд өртсөн иргэдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх	Тухай бүр	ЭМГ	Улаан загалмайн хороо, ГБХЗГ, БШУГ	
5.7	Ариутгал халдваргүйтгэлийн ажлыг шуурхай зохион байгуулах	Тухай бүр нь	ЭМГ	МЭГ, хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллагууд	
6. Цахилгаан хангамж					
6.1	Цахилгаан хангамжийн шугам сүлжээ, тоноглолын аюулгүй байдлыг хангах	Тогтмол	“Эрдэнэт-Булган” ЦТСТӨХК-ий Булган салбар	Түлш эрчим хүчээр хангах алба	
6.2	Цахилгаан эрчим хүч, цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станцыг хуваарилах байгууламж зэрэг хэрэглэгчийг болзошгүй эрсдэлээс сэргийлж, түр цахилгаан салгах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах	1 цагийн дотор	“Эрдэнэт-Булган” ЦТСТӨХК-ий Булган салбар	Түлш эрчим хүчээр хангах алба	
6.3	Нэгдүгээр ээлжийн хүч хэрэгсэл гэр хороолол, орон сууцны айл өрх, аж ахуй нэгжийн цахилгаан эрчим хүчний эрсдэлээс сэргийлж таслалт хийх, сэргээн засварлах, гэмтэл устгах, хэрэглэгчийг залгах ажлыг гүйцэтгэх	2 цагийн дотор	“Эрдэнэт-Булган” ЦТСТӨХК-ий Булган салбар	Түлш эрчим хүчээр хангах алба	
6.4	Хоёрдугаар ээлжийн хүч хэрэгсэл гэр хороолол, орон сууцны айл өрх, аж ахуй нэгжийн цахилгаан эрчим хүчний эрсдэлээс сэргийлж таслалт хийх, сэргээн засварлах, гэмтэл устгах, хэрэглэгчийг залгах ажлыг гүйцэтгэх	Шаардлагатай үед	“Эрдэнэт-Булган” ЦТСТӨХК-ий Булган салбар	Түлш эрчим хүчээр хангах алба	
6.5	Гуравдугаар ээлжийн хүч хэрэгсэл гэр хороолол, орон сууцны айл өрх, аж ахуй нэгжийн цахилгаан эрчим хүчний эрсдэлээс сэргийлж таслалт хийх,	Шаардлагатай үед	“Эрдэнэт-Булган” ЦТСТӨХК-ий Булган салбар	Түлш эрчим хүчээр хангах алба	

	сэргээн засварлах, гэмтэл устгах, хэрэглэгчийг залгах ажлыг гүйцэтгэх					
6.6	Цахилгаан хангамж тасалдсан улсын онц чухал объект, эрүүл мэндийн байгууллага зэрэг нэн шаардлагатай байгууллагуудыг цахилгаанаар хангах арга хэмжээ авах	Шаардлагатай үед	“Эрдэнэт-Булган” ЦТСТӨХК-ий Булган салбар	Түлш эрчим хүчээр хангах алба		
6.7	Цахилгаан тэжээлийг нөөц эх үүсвэрээс хангах, нөхцөл боломжийг бүрдүүлэх, шалгах	Шаардлагатай үед	“Эрдэнэт-Булган” ЦТСТӨХК-ий Булган салбар	Түлш эрчим хүчээр хангах алба		
7.Хэв журам сахиулах						
7.1	Үерт өртсөн хүч хэрэгслийг зөөж, тээвэрлэх, хэв журам сахиулах үйл ажиллагаанд 1-р ээлжийн хүч хэрэгслийг ажиллуулах	Тухай бүр	ЦГ	Замын цагдаагийн тасаг		
7.2	2-р ээлжийн хүч хэрэгслийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах, эмх замбараагүй байдал гаргуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Шаардлагатай үед	ЦГ	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага		
7.3	“Шуурхай штаб”-ын байрны үүдэнд 24 цагаар 3 ээлжид харуулын үүрэг гүйцэтгүүлэн ажилтан алба хаагч, иргэдийг орох гарах хөдөлгөөнд хяналт тавих	Шуурхай штаб байгуулагдсан даруйд	ЦГ	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага		
7.4	1-р ээлжийн хүч хэрэгслийг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөн зохицуулах, зам хаах, урсгал чиг өөрчлөх, түр зөөврийн тэмдэг тэмдэглэгээг байршуулан ажиллах	Тухай бүр	ЦГ	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага		
7.5	2-р ээлжийн хүч хэрэгслийг нэмэлтээр ажиллуулах	Тухай бүр	ЦГ	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага		

7.6	Үер усны гамшгийн үед ажиллах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж болон элс хайрга тээвэрлэж яваа том оврын ачааны автомашиныг маршрутын дагуу хөдөлгөөнд оролцуулах үеийн аюулгүй байдлыг хангах хөдөлгөөн зохицуулах, гэрлэн дохионы дэмжлэг үзүүлэх	Тухай бүр	ЦГ	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага	-
7.7	Үерт нэрвэгдсэн замын хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио хяналтын камер тэдгээрийн ажиллагааны талаарх судалгааг гаргах холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, шийдвэрлэх арга хэмжээг авах	Тухай бүр	ЦГ	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага	-
8. Ус соруулах ажиллагаа					
8.1	Нийтийн орон сууц, оффисын барилгуудын зоорийн давхрын усыг соруулах	1 цагийн дотор	"Булган-Мээж" ОНӨХХК	ОБГ	Нийт 28 ажилтан, албан хаагч, ус соруулах 6 автомашин, ус соруулах насос 11
8.2	Нийтийн гудамж талбай болон авто замын ус соруулах, зайлуулах	1 цагийн дотор	"Булган-Мээж" ОНӨХХК	Гаалийн газар	Нийт 12 ажилтан, ус соруулах 3 автомашин, ус соруулах насос 6
9. Усан хангамж, ариутгал татуурга					
9.1	Цэвэр усны эх үүсвэрийн харуул хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах	3 цагийн дотор	"Булган-Мээж" ОНӨХХК		
19.2	Үерт өртсөн хүн ам, айл өрхийг зөөврийн ундны усаар хангах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	"Булган-Мээж" ОНӨХХК	Шуурхай штаб	Зөөврийн ус түгээх байр 3ш, зөөврийн усан сан 4 тонны 5 ш, 2 тонны 3ш, усны автомашин 1ш
9.3	Ундны эх үүсвэр болон дахин дамжуулах насос станцуудаас дээж авч шинжилгээнд хамруулж холбогдох арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүр	ЭМГ	"Булган-Мээж" ОНӨХХК	
9.4	Бохир усны шугам сүлжээний хэвийн үйл ажиллагааг зохион байгуулах	Тухай бүр	"Булган-Мээж" ОНӨХХК		

10. Түр далан, суваг, шуудуу босгох

10.1	Үерийн улмаас эвдэрсэн гол болон туслах гудамж замын нөхцөл байдлыг тогтоож мэдээллэх	Тухай бүр	"Булган-А33А" ХХК	Шуурхай штаб	
10.2	Авто зам, замын байгууламж эвдэрч сүйдсэн тохиолдолд түр зам, гарам гаргах нөхцөлийг судалж тодорхойлох	Тухай бүр	"Булган-А33А" ХХК	Уул уурхайн алба	
10.3	Нэрвэгдсэн дэд бүтцийн байгууламж, зам гарцыг чөлөөлөх	Тухай бүр	"Булган-А33А" ХХК	Уул уурхайн алба	
10.4	Үерт автаж, гэмтсэн зам, гүүрний зорчих боломжийг хангах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	"Булган-А33А" ХХК	Уул уурхайн алба	
10.5	Гол, нуурын эрэг дагуу үерийн даланг босгоход шаардлагатай элс, хайрга, дайрга зөөвөрлөх ажлыг шуурхай зохион байгуулах	Тухай бүр нь	"Булган-А33А" ХХК	Булган сумын ТҮА	Элс хайрга олборлодог 3 газраас 1 экскаватор, 6 хово автомашин
10.6	Усанд автаж, гэмтсэн зам, гүүрийг сэргээх, шинээр зам тавих ажлыг зохион байгуулах	Тухай бүр	"Булган-А33А" ХХК	Уул уурхайн алба	
10.7	Замын хохирлыг гаргаж, замын байгууламж, борооны ус зайлуулах сүлжээгүй замын эзэмшигчийг тодорхойлох	Тухай бүр	Шуурхай штаб	Уул уурхайн алба	

11. Авто зам байгууламжийг чөлөөлөх

11.1	Авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	"Булган-А33А" ХХК	ЦГ	
11.2	Нэрвэгдсэн дэд бүтцийн байгууламж, зам гарцыг чөлөөлөх	Тухай бүр	"Булган-А33А" ХХК	Шуурхай штаб	
11.3	Авто зам, замын байгууламж эвдэрч сүйдсэн тохиолдолд түр зам, гарам гаргах нөхцөлийг судалж тодорхойлох	Тухай бүр	"Булган-А33А" ХХК		
11.4	Үерийн улмаас эвдэрсэн гол болон туслах гудамж замын нөхцөл байдлыг	Тухай бүр	"Булган-А33А" ХХК		

	ТОГТООЖ МЭДЭЭЛЛЭХ					
11.5	Үерт автаж, гэмтсэн зам, гүүрний зорчих боломжийг хангах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	“Булган-АЗЗА” ХХК			
11.6	Усанд автаж, гэмтсэн зам, гүүрийг сэргээх, шинээр зам тавих ажлыг зохион байгуулах	Тухай бүр	“Булган-АЗЗА” ХХК			
11.7	Замын хохирлыг гаргаж, замын байгууламж, борооны ус зайлуулах сүлжээгүй замын эзэмшигчийг тодорхойлох	Тухай бүр	Шуурхай штаб			
12.Нүүлгэн шилжүүлэх ажиллагаа						
12.1	Орон гэргүй болж, түр байранд байрласан нэрвэгдэгсдийг хоол хүнс, шаардлагатай ундны усаар хангах ажлыг зохион байгуулах	Иргэд байрласнаас хойш	УЗХ	АЗДТГ, СОК		
12.2	Түр орон байранд байрлаж буй иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх	Тухай бүр	ЭМГ	АНЭ		
12.3	Иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд сайн дурын иргэдийг ажиллуулах зохион байгуулалтад оруулах	Тухай бүр	Шуурхай штаб	УЗХ		
12.4	Үерт өртсөн гэр хороолол, зуслангийн бүсийн айл өрхийн судалгаа гарган, шинэ суурьшлын бүсэд газар олгох асуудлыг холбогдох байгууллагатай зөвшилцөж, өртсөн айл өрхийг шинээр суурьшуулах байршлыг тодорхойлох	Тухай бүр	АЗДТГ	Шуурхай штаб		
12.5	Шинэ суурьшлын бүсэд айл өрхийг суурьшуулахад шаардлагатай ус, цахилгаан хангамж, дэд бүтцээр хангах	Тухай бүр	“Эрдэнэт-Булган” ЦТСТӨХК-ий Булган салбар	Шуурхай штаб		
12.6	Иргэдийг нүүлгэн шилжүүлж, байршуулах гэр барих ажлыг зохион байгуулах	Тухай бүр	ҮАБХТЧҮБХ	Шуурхай штаб		

12.7	Нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах	Тухай бүр	ОБГ	Шуурхай штаб	
12.8	Нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүн, тээврийн хэрэгслийг томилгоожсон байранд байршуулж, нүүлгэн шилжүүлэхэд бэлтгэх	Тухай бүр	ОБГ	АЗДТГ	
12.9	Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний дагуу тогтоосон байршил, аюулгүй бүс рүү хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүд, түүх, соёлын дурсгалт зүйлийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	АЗДТГ	ОК	
12.10	Үерт өртсөн цацраг идэвхт үүсгүүрийг зөөвөрлөх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хийж хэрэгжүүлэх	Тухай бүр	ОБГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар	
12.11	Иргэдийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийг цуваанд эмхлэн зохион байгуулж, аюулгүй байдлыг ханган нүүлгэн шилжүүлэх	Тухай бүр	ЦГ	Шуурхай штаб	
12.12	Иргэд шаардлагатай бичиг баримт, хүнс, хувцас хэрэглэлийг бэлтгэн, цугларах газарт тогтоосон хугацаанд очиж, нүүлгэн шилжүүлэлт хийх томилгоот бүлгүүдийн заавар, зөвлөмжийг чанд сахиж нүүн шилжих тухай мэдээллийг хүргэх	Тухай бүр	АЗДТГ	Шуурхай штаб	
13. Лаг, шавар, бохир хог хаягдлын цэвэрлэгээ					
13.1	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, барилга байгууламжийн зоорийн давхрын лаг шаврыг зөөж, цэвэрлэх, тээвэрлэх, зайлуулах ажлыг зохион байгуулах	Ус соруулсны дараа	АЗДТГ	Булган сумын ТУА	47 албан хаагч, 7 нэгж техник хэрэгсэл

13.2	Авто замын лаг шавар, үүссэн хог хаягдыг цэвэрлэх	Тухай бүр	сумын ЗДТГ	Булган сумын ТУА	11 иргэн, 11 тээврийн хэрэгсэл
14.Ариутгал халдваргүйтгэл					
14.1	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, барилга байгууламжийн зоорийн давхрын лаг шаврыг зөөж, цэвэрлэх, тээвэрлэх, зайлуулах ажлыг зохион байгуулах	Ус соруулсны дараа	МЭГ	"Булган-АЗЗА" ХХК	
14.2	Авто зам, хорооллын дунд замын лаг шавар, үүссэн хог хаягдыг цэвэрлэх	Тухай бүр	МЭГ	"Булган-АЗЗА" ХХК	
14.3	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах	Цэвэрлэгээ дууссаны дараа	МЭГ	"Булган-АЗЗА" ХХК	
14.4	Үерийн улмаас хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүр	МЭГ	"Булган-АЗЗА" ХХК	

Тайлбар: Төлөвлөгөөний хүч хэрэгслийг жил бүрийн 4 дүгээр сард тодотгох, төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүрийн 11 дүгээр сард дүгнэх.

---000---



Булган аймгийн Засаг даргын 2024 оны
 08 дугаар сарын 18 ны өдрийн /18/ дугаар
 захирамжийн ...р хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА, МЭРГЭЖЛИЙН АНГИАС НӨХЦӨЛ БАЙДЛЫН БОЛОН ХАРИУ АРГА
 ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ХҮСНЭГТ ҮЕРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ**
 (3 цаг тутамд мэдээлэл авах хүснэгт)

д/д	Сум	Хороо /баг/	Өртсөн нийт сум, баг	Байршил	Барилга байгууламж /орон сууц тоо/	Байшин сууц тоо	Гэр сууц тоо	Аж ахуйн нэгж байгууллагын тоо	Улсын онц чухал объектын тоо	Үерт өртсөн байршлын хүн амын тоо	
										Айл өрхийн тоо	Хүн тоо
1.											
2.											
Нийт											

Үерт автсан барилга байгууламжийн зорийн давхрын усыг соруулсан байдал
 (3 цаг тутамд мэдээлэл авах хүснэгт)

д/д	Сум, баг	Өртсөн нийт барилгын тоо	Ус соруулсан байрны нийт тоо	Ажилласан ус соруулах гном, тоо	Соруулсан усны хэмжээ /тонн/	Зөөвөрлөсөн усны хэмжээ
2.						
Нийт						